



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/07

Мандалговь

Өсвөрийн шатарчдад анхан шатны
сургалт зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 15 дугаар зүйлийн 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн "Аргачлал, зардлын норматив батлах тухай" А/23,27 тоот хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд багачуудын дунд шатрын спортыг сурталчлан дэлгэрүүлэх, авьяас билгийг нээн хөгжүүлэх, тэдний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор өсвөрийн шатарчдад зориулсан сургалтыг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсугай.

2. Сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 735,000 (долоон зуун гучин таван мянга) төгрөгийн зардлыг Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хүүхдийн оролцоо, хөгжил хариуцсан мэргэжилтэн (Б.Биндэръяа)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2022 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Хүүхдийн оролцоо, хөгжил хариуцсан мэргэжилтэн (Б.Биндэръяа)-д даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

482301013


Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн
А/0.7 дугаар тушаалын 0.1 дугаар хавсралт



ӨСВӨРИЙН ШАТАРЧДАД АНХАН ШАТНЫ
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХӨТӨЛБӨР

№	Сургалтын сэдэв	Сургалтын цаг	Сургагч багш
1. “Тоглоомын дүрэм”			
1	Боломжгүй нүүдэл гэж юу вэ	09:00-11:10	“Уран өрөг” шатрын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга М.Билгүүн
2	Цайны завсарлага	11:10-11:30	
3	Анхааруулга гэж юу вэ	11:30-12:20	
4	Ямар тохиолдолд сануулга өгөх вэ?	12:00-13:00	
2. Бүх дүрсний нүүдэл			
5	Дүрмийн бус нүүдлүүд гэж юу вэ?	14:00-15:50	“Уран өрөг” шатрын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга М.Билгүүн
6	Цайны завсарлага	15:50-16:10	
7	Гараа дунд үе, төгсгөл гэж юу вэ?	16:10-17:00	

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн
А/07 дугаар тушаалын 02 дугаар хавсралт



ӨСВӨРИЙН ШАТАРЧДАД АНХАН ШАТНЫ СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Хэдэн удаа	Нийт үнэ
Цайны материал						
1	Үдийн цай (11;16)	ш	70	3,000	2	420,000
Нийт						420,000
Сургалтын хэрэглэгдэхүүн						
2	Шатар сонирхогчдын гарын авлага	ш	70	2,500	1	175,000
3	Сургагч багшийн хөлс	ш	70	2,000	1	140,000
Нийт						315,000
Дүн						735,000

----- ооо -----